

---

**2026**оны эхний улирал (3 сар)

**Гадаад оюутны тусгай элсэлт**

**[эцэг, эх нь хоёулаа гадаад, гадаадын иргэн]  
Шинээр элсэгч · шилжин суралцагчдын  
элсэлтийн заавар**

2026 Spring Undergraduate

Admissions Guide for International Students(Freshmen and Transfer)

---



**가톨릭꽃동네대학교**  
CATHOLIC KKOTTONGNAE UNIVERSITY



## Агуулга

<b>01</b> Элсэлтийн хуваарь .....	1
<b>02</b> Тавигдах шаардлага .....	1
<b>03</b> Тэнхим болон элсҮүлэх оюутны тоо .....	3
<b>04</b> Элсэлтийн журам .....	3
<b>05</b> Элсэлтийн хураамж .....	4
<b>06</b> БҮрдҮүлэх материал .....	5
<b>07</b> Төлбөр болон буцаан олголтын заавар .....	6
<b>08</b> Тэтгэлгийн мэдээлэл .....	7
<b>09</b> Дотуур байрны мэдээлэл .....	8
<b>10</b> БҮртгҮүлэгчдийн анхаарах зҮйлс .....	10

## 01 Элсэлтийн хуваарь

※ БҮх бичиг баримтыг заавал өргөдөл хҮлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө (Солонгосын цагаар) бҮрдҮүлэн өгсөн байх шаардлагатай бөгөөд, хугацаандаа өгөөгүй тохиолдолд элсэлтийн шаардлага хангаагҮйд тооцно.

▶ Эцэг, эх нь хоёулаа гадаад, гадаадын иргэн

Элсэлтийн агуулга	Хуваарь	Тайлбар
Өргөдөл хҮлээн авах	2025.11.03.(Да) ~ 2025.11.12.(Лха) 18:00 цаг хҮртэл	Элсэлтийн хураамж (30,000 вон) шилжҮүлсний дараа бҮртгэл баталгаажна.
Бичиг баримт бҮрдҮүлж, ирҮүлэх	2025.11.14.(Ба) 18:00 цаг хҮртэл	Бичиг баримт хҮлээн авах газар: Католик Олон Улсын Боловсролын Төв (Жихегуан 204 тоот) 가톨릭국제교육원(지혜관 204호) Илгээх арга: Өөрийн биеэр эсвэл шуудангаар
Ярилцлагын дҮн	2025.11.20.(ПҮ) ~ 2025.11.22.(Бя)	Гадаадад амьдарч байгаа тохиолдолд цахим ярилцлагад орно.
Элсэлтийн хариу зарлах	2025.12.03.(Лха) 15:00	ХҮн тус бҮрт мэдэгдэж, сургалтын төлбөрийн нэхэмжлэхийг имэйлээр илгээнэ.
Төлбөр төлөх	2025.12.08.(Да) ~ 2025.12.10.(Лха) хҮртэл	Хугацаандаа багтаж бҮртгҮүлээгүй бол тэнцээгҮйд тооцно.

## 02 Тавигдах шаардлага

1) Иргэншил болон сургалтын хөтөлбөр

- Эцэг, эх нь хоёулаа гадаад, гадаадын иргэн

※ БНСУ-ын иргэншилгүй байх

2) Боловсролын тҮвшин

Ангилал	Суурь боловсролын нөхцөл
Шинэ элсэгч	Дотоод · гадаадын албан ёсны ахлах сургуулийн хөтөлбөрийг төгссөн, эсвэл хууль тогтоомжийн дагуу тҮҮнтэй тэнцэх буюу тҮҮнээс дээш боловсролтойд тооцогдох хҮн.
Шилжин суралцагч	Дээр дурдсан шинээр элсэгчийн шаардлагыг хангасан оюутнууд дундаас дараах нөхцөлийг хангасан байх: ※ 3-р курс: Дотоод болон гадаадын их, дээд сургууль төгссөн (эсвэл төгсөх гэж буй), 4 жилийн сургалттай их сургуулийн 2-р курс (4 улирал)-ийг дҮҮргэсэн (эсвэл дҮҮргэх гэж буй), мөн хууль ёсоор тҮҮнтэй тэнцэх буюу тҮҮнээс дээш боловсролтой хҮн.

※ Ахлах сургуулийн төгсөгч болон тҮҮнтэй тэнцэх боловсролын тҮвшний хҮлээн зөвшөөрөгдөх хҮрээ

• Бага, дунд боловсролын тухай хуулийн 98-р зҮйл (Ахлах сургуулийн төгсөгч болон тҮҮнтэй тэнцэх боловсролын хҮлээн зөвшөөрөх хҮрээ – 1-р хэсэг, 9-р заалт)

Сургалтын хугацаа			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
БНСУ	12	6-3-3-4	6 жил				3 жил			3 жил			4 жил					
Гадаадын боловсролын тогтолцоо	12	5-3-4-4	5 жил				3 жил			4 жил			4 жил					
	13	6-4-3-3	6 жил				4 жил			3 жил			3 жил					
	11	6-3-2-5	6 жил				3 жил			2 жил		5 жил						
	13	2-4-3-4-3	2 жил	4 жил			3 жил			4 жил			3 жил					
	12	8-4-4	8 жил						4 жил			4 жил						

- 1 улсад бага, дунд сургуулийн бҮх хөтөлбөрийг бҮрэн дҮүргэсэн тохиолдолд хҮлээн зөвшөөрнө.
- 2 буюу тҮҮнээс дээш улсад 12 жилийн боловсролын хөтөлбөрийг дҮүргэсэн бол хҮлээн зөвшөөрнө. Харин 11 жилийн хөтөлбөрийг хҮлээн зөвшөөрөхгүй бөгөөд, Солонгост ахлах сургуульд дахин элсэх эсвэл шилжин суралцах ёстой. *(Гэхдээ 11 жилийн хөтөлбөрийн хувьд бага, дунд сургалтын сҮҮлийн 3 жилийг нэг улсад дҮүргэсэн тохиолдолд л ахлах сургуулийн хөтөлбөрөөр хҮлээн зөвшөөрнө.)*
- Тухайн улсын боловсролын тогтолцооноос болж сургалтын хугацаа дутуу байвал тухайн улсын их дэ эд сургуульд суралцсан хугацааг ахлах сургуульд суралцсан хугацаанд тооцно.
- ※ Тухайн улсын сургалтын нийт хугацаа ба БНСУ-ын Боловсролын яамнаас тогтоосон 12 жилийн сургалтын хугацааны ялгааг бодож тооцно.

### 3) Хэлний чадвар (Шинэ элсэгч / Шилжин суралцагч)

- **Дээр дурдсан шаардлага биелүүлсэн бол доор дурдсан шаардлагаас нэгийг биелүүлсэн байх**

Элсэлтийн төрөл	Тэнхим	Хэлний шалгуур
Эцэг, эх нь хоёулаа гадаад, гадаад элсэгч	Сувилахуйн сургууль	Солонгос хэлний тҮвшин тогтоох шалгалт (ТОPIK) 4 тҮвшнээс дээш
	Чөлөөт мэргэжлийн тэнхим	Солонгос хэлний тҮвшин тогтоох шалгалт (ТОPIK) 3 тҮвшнээс дээш

- ※ Зөвхөн чөлөөт мэргэжлийн тэнхимд элсэн суралцагч Солонгос хэлний тҮвшин тогтоох шалгалт (ТОPIK) 2 тҮвшинтэйгээр орох боломжтой бөгөөд элссэний дараа 1 жилийн дотор 300-аас дээш цагийн Солонгос хэлний сургалт (тэнхимийн хичээлээс гадна тухайн их сургуулийн хэлний сургалтын хөтөлбөр), эсвэл ижил хөтөлбөртэй сургуулийн хэлний бэлтгэл, СэжҮн Хагданы Солонгос хэлний сургалтын аль нэгд заавал суусан байх шаардлагатай.

### 03 Тэнхим болон элсүүлэх оюутны тоо

#### 1) Шинэ элсэгч

Ангилал	Тэнхим	Элсүүлэх оюутны тоо	Тайлбар	
Шинэ элсэгч	Сувилахуйн тэнхим	Хязгааргүй	-	
	Чөлөөт мэргэжлийн тэнхим	Хязгааргүй	1-р курс	Ирээдүйн замаа тодорхойлох, мэргэжлээ сонгох (Ерөнхий мэргэжлийн хичээлүүд)
			2-р курс	①Дан мэргэжил сонгох : Нийгмийн ажилтан эсвэл Сэтгэл Судлал
				②Давхар мэргэжил сонгох : Нийгмийн ажилтан болон Сэтгэл Судлал ③Нэмэлт сонголт: Дэд мэргэжил эсвэл бусад мэргэжил (Хосолсон нэгдмэл хөтөлбөр)

※ Элсэхийн өмнө заавал элсэлтийн албаны ажилтантай зөвлөлдөж, элсэх боломжтой эсэхийг шалгуулна уу.

#### 2) Шилжин суралцагч

Ангилал	Тэнхим	Элсүүлэх оюутны тоо	Боломжит курс	Тайлбар
Шилжин суралцагч	Сувилахуйн тэнхим	Хязгааргүй	3-р курс	Өмнө суралцаж байсан их сургуультай ижил тэнхим (мэргэжил)-д л өргөдөл гаргах боломжтой.
	Нийгмийн ажилтан · Сэтгэл Судлал	Хязгааргүй	3-р курс	

※ Элсэхийн өмнө заавал элсэлтийн албаны ажилтантай зөвлөлдөж, элсэх боломжтой эсэхийг шалгуулна уу.

### 04 Элсэлтийн журам

Элсэлтийн төрөл	Тэнхим	Элсэлтийн арга	Шалгаруулалтын бүрэлдэхүүн хэсэг ба тусгах хувь		Шалгаруулалтын нийт оноо
			ЕБС дүн (хамгийн их оноо /хамгийн бага оноо)	Ярилцлага (хамгийн их оноо /хамгийн бага оноо)	
Эцэг, эх нь хоёулаа гадаад, гадаад элсэгч	БҮГД	Нэг дор	-	100% [хамгийн их 500 оноо / хамгийн бага 50 оноо]	500 оноо

※ Өргөдөл гаргагчийн Үнэлгээний нарийвчилсан мэдээлэл болон тэнцээгүй шалтгааныг нийтэд **ил зарлахгүй** болно.

## 05 Элсэлтийн хураамж

1) Элсэлтийн хураамж: KRW 30,000

2) Шилжүүлэх арга

A. Дансаар шилжүүлэх эсвэл банкны данс ашиглахгүй шилжүүлэг хийх

**B. Шилжүүлэх данс: Манай их сургуулийн заасан данс руу төлбөрөө хийх (хувиар мэдэгдэнэ).**

C. Өргөдөл хүлээн авах хугацаанд элсэлтийн хураамж төлөөгүй тохиолдолд бүртгэл автоматаар цуцлагдана.

3) Элсэлтийн хураамж буцаан олгох журам

Шалтгаан	Буцаан олгох мөнгөн дүн
Элсэлтийн шалгалтад оролцогч санамсаргүйгээр илүү төлбөр төлсөн тохиолдолд	Илүү төлсөн төлбөр
Сургуулийн буруугаас болж элсэлтийн шалгалтад оролцож чадаагүй тохиолдолд	
Байгалийн гамшгийн улмаас элсэлтийн шалгалтад оролцож чадаагүй тохиолдолд	Шилжүүлсэн элсэлтийн хураамжийн тодорхой хувь
Өвчин, ослын улмаас эмнэлгийн байгууллагад хэвтэн эмчлүүлэх, эсвэл өөрийн нас баралтаас болж элсэлтийн шалгалтад оролцож чадаагүй тохиолдолд (шалтгааныг нотлох боломжтой тохиолдолд л хамаарна)	эсвэл бүтэн төлбөр
Шат дараалан явагддаг элсэлтийн шалгаруулалтад оролцсон боловч эцсийн шатнаас өмнө тэнцээгүй тохиолдолд	

## 06 БҮрдҮүлэх материал

► Эцэг, эх 2 нь хоёулаа гадаад, гадаадын иргэн

No	БҮрдҮүлэх материал	Элсэлтийн шалгаруулалтын төрөл		Анхаарах зүйл
		Шяг элэгч	Шилжин суралцагч	
01	Элсэлтийн анкет	0	0	
02	Суралцах төлөвлөгөө	0	0	
03	Боловсролын талаарх лавлагаа авах зөвшөөрөл	0	0	Сургуулийн маягыг ашиглана
04	Хувийн мэдээлэл цуглуулах ашиглах зөвшөөрөл	0	0	
05	Орчуулагчийн	0	0	
06	Ахлах сургуулийн гэрчилгээ	0 орчуулга, нот ариат	Х	
07	Ахлах сургуулийн дүнгийн тодорхойлолт	0 орчуулга, нот ариат	Х	Хамгийн сүүлд төгссөн сургууль (0)-д хамаарна <БНХАУ-д боловсрол эзэмшигчид> Боловсролын яамны боловсролын зэрэг баталгаажуулалтын тайлан (CHSI) эсвэл CHSI-г өгөх боломжгүй тохиолдолд Apostille батламж
08	Их сургуулийн төгссөн / суралцаж буй гэрчилгээ	Х	0 орчуулга, нот ариат	<БНХАУ-аас бусад улсад боловсрол эзэмшигчид> Apostille батламж <Шилжин суралцагчийн дүнгийн тодорхойлолт> Нийт кредитийг заасан дүнгийн хуулгыг хүлээн зөвшөөрнө (Кредит бичигдээгүй дүнгийн хуулгыг хүлээн зөвшөөрөхгүй)
09	Их сургуулийн бүүх улирлын дүнгийн тодорхойлолт ※ 편입학 지원자는 학점인정 심사	Х	0 орчуулга, нот ариат	Ладлагын гэрчилгээнд кредит бичигдсэн бол зөвшөөрнө
10	Паспортын хуулбар	0	0	
11	Өргөдөл гаргагч болон эцэг, эхийн иргэний харьяатны лавлагаа	0	0	
12	Төрөл садангийн лавлагаа (Төрийн байгууллагаас авсан)	0	0	<БНХАУ-ын иргэн > Өөрийн болон эцэг эхийн Хукубу [орчуулгыг нотариатаар баталгаажуулсан байх] Гэр бүлийн харилцааны тодорхойлолт [орчуулгыг нотариатаар баталгаажуулсан байх] <БНХАУ-аас бусад улсын иргэн> Төрийн байгууллагаас олгосон өргөдөл гаргагч болон эцэг, эхийн харилцааг нотлох тодорхойлолт [орчуулгыг нотариатаар баталгаажуулсан байх]
13	Батлан даагчийн дансны хуулга (16 сая воноос дээш мөнгөн дүнг / 1 сараас дээш хугацаанд дансандаа байлгах)	0	0	
14	Санхүүгийн батлан даагчийн ажлын газрын тодорхойлолт болон орлогын тодорхойлолт	0	0	
15	Оршин суух Үнэмлэхийн хуулбар / паспортын хуулбар	0	0	Хамаарах тохиолдолд (оюутан болон эцэг эх)
16	Хэлний шалгалтын дүнгийн тодорхойлолт (TOPIK гэх мэт)	0	0	Хамаарах тохиолдолд
17	Элсэлтийн хураамж төлсөн баримт	0	0	
18	Католик шашны санваартны тодорхойлох захидал	0	0	Хамаарах тохиолдолд (илгээсэн тохиолдолд давуу эрх олгоно)

※ Өргөдөл гаргагчийн визтэй, визгүйгээс шалтгаалан БҮрдҮүлэх материал нэмэгдэх эсвэл хасагдах боломжтой.

※ Баримт бичиг БҮрдҮүлэхэд анхаарах зүйлс

• Солонгос эсвэл Англиас өөр хэл дээрх бичиг баримтыг заавал Солонгос эсвэл Англи хэл дээр орчуу

лан орчуулгыг нотариатаар баталгаажуулсан байх.

- БҮх бичиг баримтыг материал хҮлээн авах эцсийн хугацаанаас өмнө 1 жилийн дотор авсан байх ёстой.

(Хэлний чадвар нотлох баримт бичигт хҮчинтэй хугацаа хамаарахгүй.)

- Бичиг баримтыг Үндсэн эх хувиар нь хураалгах бөгөөд өгсөн бичиг баримтыг буцаан олгохгүй.
- Төгсөх ангийн өргөдөл гаргагч нь эхлээд “төгсөх гэж буй тухай гэрчилгээ”-г гаргаж өгөх ба дараа нь “төгссөн тухай гэрчилгээ”-г нэмэлтээр гаргаж өгөх ёстой.

(Хэрэв төгссөн гэрчилгээгээ өгөөгүй тохиолдолд тэнцсэн шийдвэрийг хҮчингҮй болгоно.)

- Эцсийн байдлаар тэнцсэн тохиолдолд өргөдөл гаргагчийн гаргасан “боловсролын лавлагаа авах зөвшөөрөл”-д Үндэслэн төгссөн сургуулийн лавлагааг шалгах бөгөөд хэрэв боловсролын лавлагаа ирҮүлээгүй тохиолдолд элсэлтийг цуцалж болно.
- Өргөдөл дээрх холбоо барих мэдээлэл (амьдарч буй хаяг болон утасны дугаар)-ийг буруу бичсэн эсвэл холбоо барих боломжгүйгээс шалтгаалан мэдэгдэл хҮргэх боломжгүй болж, тэнцсэн шийдвэр хҮчингҮй болсон тохиолдолд манай их сургууль хариуцлага хҮлээхгүй болно.

## 07 Сургалтын төлбөр болон төлбөр буцаан олголтын журам

1) Сургалтын төлбөр (2025 оны хичээлийн жилийн байдлаар)

(нэгж: вон)

Салбар болон тэнхим	Төлбөр
Сувилахуйн тэнхим	KRW 3,973,000
Чөлөөт мэргэжлийн тэнхим	KRW 3,384,000

※ Дээр дурдсан төлбөр өөрчлөгдөж болно (сургалтын төлбөр төлсний дараа ч тус сургуулийн бодлого өөрчлөгдвөл нэмэлт төлбөр гарч болзошгүй).

2) Төлбөр буцаан олголтын журам

- Семестр эхэлсэн өдрөөс эхлэн дараах ангиллын дагуу төлбөрийг буцаан олгоно (Их сургуулийн сургалтын төлбөрийн дҮрмийн 6-р зҮйл, 2-р хэсэгт заасны дагуу)

Төлбөр буцаах хҮсэлт гаргасан өдөр	Буцаан олгох дҮн	Суутгах дҮн
Семестр эхэлсэн өдрөөс 14 хоногийн дотор	Нийт төлбөр	Байхгүй
Семестр эхэлснээс 14 хоног өнгөрсөн өдрөөс хойш 30 хоног хҮртэл	Төлбөрийн 5/6	Төлбөрийн 1/6
Семестр эхэлснээс 30 хоног өнгөрсөн өдрөөс хойш 60 хоног хҮртэл	Төлбөрийн 2/3	Төлбөрийн 1/3
Семестр эхэлснээс 60 хоног өнгөрсөн өдрөөс хойш 90 хоног хҮртэл	Төлбөрийн 1/2	Төлбөрийн 1/2
Семестр эхэлснээс 90 хоног өнгөрсний дараа	Буцаалт хийхгүй	Нийт төлбөр

## 08 Тэтгэлгийн мэдээлэл

### 1) Шинэ элсэгч (Эхний семестрт л хамаарна)

Ангилал	Тэтгэлгийн нэр	Олгох хугацаа	Хөнгөлөлт авах хҮН	Олгох дҮн (хөнгөлөлт)
Шинэ элсэгч	Сургуулийн тэтгэлэг	Эхний семестр	Сувилахуйн тэнхимийн шинэ элсэгч (Шилжин суралцагчид хамаарахгүй)	1,000,000 вон
			Чөлөөт мэргэжлийн тэнхимийн шинэ оюутан (Шилжин суралцагчид хамаарахгүй)	Нийт сургалтын төлбөр
	Дотуур байрны тэтгэлэг	Эхний семестр	Их сургуулийн дотуур байранд амьдрах шинэ оюутан (Шилжин суралцагчид хамаарахгүй)	Дотуур байр ашиглалтын нийт төлбөр (2 хҮний өрөө, хоолны мөнгө болон барьцаа мөнгө хасагдана)

### 2) Суралцаж буй оюутан (2 дахь семестрээс эхлэн хэрэгжинэ)

Ангилал	Тэтгэлгийн нэр	Хөнгөлөлт авах хҮН	Олгох дҮн (хөнгөлөлт)	Олгох хугацаа	Тайлбар	
Суралцаж буй оюутан	ДҮнгийн тэтгэлэг	ДҮн А	Өмнөх семестрийн голч дҮн нь сурч буй оюутнуудын дундаас дээд 2%-д багтсан байх	Сургалтын нийт төлбөр	тухайн семестр	-
		ДҮн В	Өмнөх семестрийн голч дҮн нь сурч буй оюутнуудын дундаас дээд 5%-д багтсан байх	Сургалтын төлбөрийн 50%		
		ДҮн С	Өмнөх семестрийн голч дҮн нь сурч буй оюутнуудын дундаас дээд 12%-д багтсан байх	KRW 1,000,000		
	ТОРИК-ийн тэтгэлэг	ТОРИК 6 тҮвшин	Сургалтын төлбөрийн 50%	суралцаж байх хугацаанд	-	
		ТОРИК 5 тҮвшин	Сургалтын төлбөрийн 40%			
		ТОРИК 4 тҮвшин	Сургалтын төлбөрийн 30%			
	Дотуур байрны тэтгэлэг	ДҮнгийн голч 4.0-ээс дээш ТОРИК 5 тҮвшингээс дээш	Дотуур байрны нийт төлбөр	тухайн семестр	2 хҮний өрөө, хоолны мөнгө болон барьцаа мөнгө хасагдана	
		ДҮнгийн голч 3.0-аас дээш ТОРИК 4 тҮвшингээс дээш	Дотуур байрны төлбөрийн 50%			
		ДҮнгийн голч 3.0-аас дээш ТОРИК 3 тҮвшингээс дээш	Дотуур байрны төлбөрийн 30%			

※ Гадаад оюутан элсүүлэх журмаар элссэн шинээр элсэгч болон суралцаж буй оюутнуудад олгоно.

※ Гадаад оюутны шинээр элсэгчийн тэтгэлэг нь зөвхөн элссэн семестрт нэг удаа олгогдоно.

※ Албан ёсны хэлний шалгалтын дҮн нь хҮчинтэй хугацаанаас Үл хамааран хҮлээн зөвшөөрөгдөнө.

※ ТОРИК-ийн хувьд "Боловсролын Яамны Үндэсний Олон Улсын Боловсролын ХҮрээлэн"-гээс зохион байгуулсан шалгалтын дҮнг л хҮлээн зөвшөөрнө.

※ Хэрэв Солонгосын иргэншил авсан тохиолдолд гадаад оюутны тэтгэлэг олголт зогсоно.

## 09 Дотуур байрны танилцуулга

1) Элсэлтийн өргөдөл явуулах Үедээ дотуур байранд орох хҮсэлт давхар гаргах

2) Дотуур байрны төлбөр

1. Орох хҮсэлт : Элсэлтийн анкет дээр дотуур байранд орох хҮсэлтэй эсэхээ тэмдэглэнэ.

2. Оршин суух хугацаа : 2026.03.02 (Даваа) ~ 2026.06.20 (Бямба) / 1 семестр

3. Дотуур байрны төлбөр

- Семестрийн хугацаанд: 1 семестрийн байрны төлбөр (111~112 хоног) **【2025 оны 1-р семестрийн байдлаар】**

Ангилал		Ашиглалтын хураамж (зон)	Тайлбар
2 хҮний өрөө (Өдөрт 1 хоол)	Ашиглалтын төлбөр	KRW 800,000	Нийтийн усанд орох өрөө болон ариун цэврийн өрөө
	ТҮлхҮҮрийн барьцаа	KRW 5,000	
	Хоолны мөнгө (1 хоол)	KRW 333,000	
	Нийт	KRW 1,138,000	
2 хҮний өрөө (Өдөрт 2 хоол)	Ашиглалтын төлбөр	KRW 800,000	
	ТҮлхҮҮрийн барьцаа	KRW 5,000	
	Хоолны мөнгө (2 хоол)	KRW 636,400	
	Нийт	KRW 1,441,400	

\* Дотуур байранд орох тогтсон өдрөөс өмнө дотуур байранд орохыг хҮссэн оюутан нь урьдчилсан байрлах хугацааны ашиглалтын хураамжийг тусад нь төлөх ёстой.

3) Гадаад шинэ-шилжин суралцагч оюутны дотуур байранд орох хугацаа

- **2026.02.27.(Ба) ~ 2026.03.01.(Ня) (Дотуур байранд орох цаг: 15:00~20:00)**

4) Дотуур байранд орсон оюутан гарах Үед буцаан олголт хийх журам

Гарах өдөр	Төлбөр	Хоолны мөнгө
Амьдрах хугацааны 1/4 өнгөрөхөөс өмнө (4 долоо хоног)	Төлбөрийн 3/4 буцаан олгох	Өдрөөр тооцох
Амьдрах хугацааны 2/4 өнгөрөхөөс өмнө (8 долоо хоног)	Төлбөрийн 2/4 буцаан олгох	
Амьдрах хугацааны 3/4 өнгөрөхөөс өмнө (12 долоо хоног)	Төлбөрийн 1/4 буцаан олгох	
Амьдрах хугацааны 3/4 өнгөрсний дараа	Буцаан олголт хийхгүй	

※ Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтөөс хамааран дотуур байрны ашиглалтын хураамжийг долоо хоногоор тооцох тохиолдолд, орох хугацааны 3/4 өнгөрөхөөс өмнө бол аль хэдийн амьдарсан долоо хоног болон гарсан долоо хоногийг хасаж, Үлдсэн долоо хоногийн хураамжийг долоо

хоногоор тооцон буцаан олгоно. Харин орох хугацааны 3/4 өнгөрсний дараа бол буцаан олгохгүй.  
 ✖ Дээрх нөхцөл байдал нь тухайн Үеийн нөхцөл байдлаас хамааран өөрчлөгдөж болно.

5) Үндсэн байгууламж болон туслах байгууламж

- Үндсэн байгууламж: ор, хувцасны шүүгээ, ширээ, гутлын шүүгээ, угаалгын өрөө, усанд ордог өрөө, хувцас угаах өрөө (угаалгын машинтай)
- Туслах байгууламж: суралцах өрөө, компьютерын өрөө, семинарын өрөө, амралтын өрөө, фитнесийн өрөө, залбирлын өрөө гэх мэт

6) Бусад мэдээлэл

Орох Үед авчрах зүйлс	Эрүүл мэндийн Үзлэгийн хуудас (цээжний Х-гау шинжилгээ, улаанбурханы вакцины баталгаа)
Оруулахыг хориглосон зүйлс	Цахилгаан халаагуур болон цахилгаан хэрэгсэл (ус буцалгагч, халдаг гудас, цахилгаан халаагуур, агаараар шарагч гэх мэт), хориотой эм бэлдмэлүүд $\frac{\text{H}}{\text{E}}$
Нийтийн хэрэглээний төхөөрөмжүүд	Хөргөгч, Хөлдөөгч, Богино долгионы зуух, TV, Тоос сорогч, Талх шарагч, Индүү
Компьютерын өрөө	Компьютер, принтер (төлбөртэй)

☎ Холбогдох утас: Дотуур байр (043-270-0411)

7) Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд Үзүүлэх дэмжлэг

- Католик Гудтун-нэ Их сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй оюутны сурах эрхийг хамгаалах, боловсролын халамжийн Үйлчилгээ Үзүүлэхийн төлөө бҮхий л хүчээ дайчлан ажиллаж байна.
- Хөгжлийн бэрхшээл болон бусад шалтгааны улмаас дэмжлэг шаардлагатай тохиолдолд зөвлөгөө авч, суралцах Үйл явц болон цаашдын амьдралаа төлөвлөхөд чиглэсэн Үйлчилгээ авах боломжтой.

Хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулсан зөвлөгөө	Мэргэжлийн зөвлөх болон их сургуулийн амьдрал, ажилд орох, тэтгэлэгтэй холбоотой зөвлөгөө мэдээлэл
Их сургуулийн амьдралд дасан зохицоход туслах дэмжлэг	Хөгжлийн бэрхшээлтэй оюутны туслагч, хичээл сонголт, тэтгэлэг, төрөл бүрийн хөтөлбөрийн дэмжлэг гэх мэт
Суралцахад зориулсан туслах хэрэгслийн дэмжлэг	Чихэвч, DAISY тоглуулагч, цахилгаан тэргэнцэр, бичиг томруулагч төхөөрөмж зэргийн дэмжлэг

☎ Холбогдох утас: Оюутанд туслах алба, Оюутны хэлтэс 043-270-0162

## 10 Өргөдөл гаргагчийн анхаарах зүйлс

### 1) Бичиг баримтын Үндсэн шаардлага

- ① Нэр, гадаад дахь хаяг зэрэг онцгой тохиолдлоос бусад бҮх зүйлсийг заавал Солонгос хэлээр бөглөх
- ② Нэр болон Үнэмлэхийн дугаар зэрэг мэдээлэл нь тухайн улсын засгийн төрийн байгууллагаас олгосон лавлагаатай (орон нутгийн байгууллагаас олгосон) таарч байх ёстой
- ③ Зураг нь сҮҮлийн 3 сарын дотор авхуулсан байх ёстой (малгайтай зураг Х, зурсан зураг Х)
- ④ Шалгаруулалтын явцад холбоо барих боломжтой байхын тулд хаяг, утасны дугаарыг зөв, тодорхой бичих
- ⑤ Өргөдөлд гарсан алдаа, бичилт дутуу, уншигдахгүй байдал зэрэг шалтгаанаас ҮҮсэх бҮх хариуцлагыг өргөдөл гаргагч өөрөө хҮлээнэ.

### 2) Хятадын боловсрол, зэрэг баталгаажуулалтын тайлан хҮсэх арга

- ① Боловсролын гэрчилгээ : БНХАУ-ын Үндэсний Дээд Боловсролын Оюутны Мэдээлэл, Ажил эрхлэлтийн Зөвлөх төв

(Боловсролын яамны Боловсролын баталгаажуулалтын төв, <http://www.chsi.com.cn>)

- ② Зэрэг баталгаажуулалт : Хятадын Зэрэг ба Судалгааны Боловсролын Хөгжлийн Төв

(Боловсролын яамны Зэрэг баталгаажуулалтын төв, [www.cdgd.edu.cn](http://www.cdgd.edu.cn))

- ③ Солонгост байрлах албан ёсны төлөөлөгч байгууллага болох СөҮл Конфуций Академи

(Хан-Хятадын Соёлын Хамтын Ажиллагааны Судалгааны ХҮрээлэн, <http://www.cis.or.kr>)

(Лавлах утас: 02-554-2688)

※ Баталгаажуулалтын гэрчилгээ олгоход ойролцоогоор 30 хоног шаардагддаг тул урьдчилан бэлтгэх шаардлагатай

### 3) Тэнцсэн тохиолдолд анхаарах зүйлс

- ① Манай их сургуулийн элсэлтийн улиралтай ижил хугацаанд 2 ба түүнээс дээш их сургуульд зэрэг бүртгүүлэх боломжгүй.

(Бусад их сургуулийн гадаадад байгаа иргэд болон гадаад оюутны тусгай шалгаруулалтад зэрэг тэнцсэн бол заавал нэг сургуульд л бүртгүүлэх ёстой.)

Мөн уг шалгаруулалтад тэнцсэн өргөдөл гаргагчид энгийн элсэлт, нэмэлт элсэлтэд дахин өргөдөл гаргах боломжгүй бөгөөд дээрх заалтыг зөрчвөл тэнцсэн эрхийг хҮчингҮй болгоно.

- ② Манай их сургуульд тэнцсэн байсан ч виз олгогдоогүй тохиолдолд тэнцсэн болон элсэх эрхийг хҮчингҮй болгоно.

### 4) Бусад

- ① Элсэлтийн журамд заагаагүй асуудлыг манай их сургуулийн элсэлтийн Үнэлгээний дҮрэм журмын дагуу шийдвэрлэнэ.

- ② Энэхүү элсэлтийн журамд заасан зүйлс нь журам боловсруулсан Үеийн нөхцөл байдал бөгөөд элсэх Үед өөрчлөгдөх боломжтой тул заавал элсэлтийн ажилтантай зөвлөлдөн шаардлагыг эцэслэн

баталгаажуулах шаардлагатай.

- ③ Гадаад оюутнууд эрүүл мэндийн даатгалд заавал хамрагдах журамтай тул тэнцсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалд заавал бүртгүүлэх ёстой.
- ④ Манай сургуулийн дотоод журамд заасны дагуу төгсөх Үеийн хэлний шаардлага: 7|E†
- Солонгос хэлний түүвшин тогтоох шалгалт болох (ТОPIK) 4-р түүвшин буюу түүнээс дээш оноо авсан тохиолдолд төгсөх эрх олгоно.

**Элсэлтийн лавлах: Католик Гудтун-нэ Их Сургууль, Католик Олон Улсын Боловсролын Алба**

- Утас : +82-43-270-0125
- Факс : +82-43-270-0117
- И-мэйл : [bsh@kkot.ac.kr](mailto:bsh@kkot.ac.kr)
- Хаяг : 28211, БНСУ, Чүнчонбук-до, Чончү хот, Сөвон-гу, Хёндо-мен, Сансам гил 133, Жихе Гван 204 тоот (133 Sangsam-gil, Hyundo-myeon, Seowon-gu, Cheongju-si, Chungbuk, 28211, Republic of Korea)